



НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/326

Улаанбаатар хот

Тамхи худалдах тусгай зөвшөөрөл  
олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 16 дугаар зүйлийн 16.3.4, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалт, 2020 оны 06 дугаар сарын 25-ний өдрийн худалдаа, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 04 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тамхи худалдаалах тусгай зөвшөөрлийг сунгах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын жагсаалтыг хавсралтаар баталж тусгай зөвшөөрлийг олгосугай.

2. Тусгай зөвшөөрөл олгогдсон аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын хэлтэс /Б.Нарангэрэл/-т, цагдаагийн газар /цагдаагийн хурандаа С.Буянжаргал/-т, тэмдэгтийн хураамжийг дүүргийн Татварын хэлтсийн дансанд, гэрчилгээний үнийг дүүргийн Тамгын газрын дансанд төвлөрүүлж ажиллахыг Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс /Э.Сансар/-т тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эдийн засаг, худалдаа үйлчилгээ, тохижилт нийтийн аж ахуйн асуудал хариуцсан төслийн удирдагч /Э.Батбилэг/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.ОДОНТУЯА